

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАГДСАН ИНД-101-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p>Хүнгүй агаарын хөлөг, пуужин, жиро-глайдер болон парасэйлийн үйл ажиллагааны дүрэм (Шинэчлэгдэж байгаа) /24 хуудас/ 2017 оны NZ amend.8</p>	<p>ХҮНГҮЙ НИСДЭГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ЖИРОПЛАНЕР - ҮЙЛ АЖИЛЛАГАА (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /13 хуудас (үндсэн дүрэм-36 хуудастай байсан)/1997 оны NZ original</p>	<p>Тайлбар</p>
<p><b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b> <b>101.1. Хамрах хүрээ</b> Энэ Дүрэм нь ИНД-102.21-д хамааралтайгаар, дараах төхөөрөмжийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) <a href="#">аргамжаат бөмбөлөг</a> болон цаасан шувуу; (2) чөлөөт бөмбөлөг; (3) пуужин; (4) <a href="#">алсын удирдлагатай агаарын хөлөг, үтсан удирдлагатай агаарын хөлгийн загвар болон чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар</a>; (5) <a href="#">жиро-глайдер болон парасэйл</a></p>	<p><b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b> <b>101.1. Зорилго</b> (а) Энэ дүрмийн зорилго нь дараах нисдэг төхөөрөмжүүдийн үйл ажиллагааг зохицуулахад оршино:  1/ <a href="#">хийн бөмбөлөг</a> ба цаасан шувуу; 2/ пуужингийн загвар; 3/ агаарын хөлгийн загвар; 4/ <a href="#">жиропланер</a>.</p>	<p>-ИНД-102-той уялдуулж өгсөн.  -Amend.6-аар нэмэгдсэн  -Хийн бөмбөлөг гэснийг Аргамжаат болон чөлөөт бөмбөлөг гэж ялгасан.  -Жиропланер гэснийг жироглайдер болгож өөрчилсөн.  -Парасэйл гэж нэмж оруулсан.</p>
<p><b>101.3. Нэр томьёо ба товчлол</b> Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.;</p>	<p><b>101.3. Тодорхойлолт</b></p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p><b>101.5. Бүртгэл</b> ИНД-47-гийн шаардлага нь хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, пуужин, парасэйл болон жиро-глайдерт хамаарахгүй.</p>	<p><b>101.5. Бүртгэл</b> (а) Энэ дүрмээр зохицуулагдах нисэх болон хөөрөх төхөөрөмж, загваруудад ИНД-47–д заагдсан улсын бүртгэл, таних тэмдгийг шаардахгүй.</p>	
<p><b>101.7. <a href="#">Хязгаарлалттай</a>, цэргийн үйл ажиллагааны болон аюултай бүс</b> (а) Хязгаарлалттай бүсийн үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаас бусад</p>	<p><b>101.7. <a href="#">Хориотой</a> болон цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүс, аюултай бүс</b> (а) Нислэгийн Хөдөлгөөний Үйлчилгээ (цаашид НХҮ гэх)-ний холбогдох байгууллагаас зөвшөөрөл олгогдоогүй тохиолдолд,</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>тохиолдолд, аливаа этгээд нь <a href="#">ИНД-71</a>-ийн дагуу тогтоосон <a href="#">хязгаарлалттай</a> бүсэд хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, <a href="#">жиро-глайдер</a>, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>(b) Цэргийн үйл ажиллагааны бүсийн үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь <a href="#">ИНД-71</a>-ийн дагуу тогтоосон цэргийн үйл ажиллагааны бүсэд хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, <a href="#">жиро-глайдер</a>, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>(c) Аюултай бүстэй холбоотой тухайн үйл ажиллагаа нь <a href="#">жиро-глайдер</a>, эсхүл парасэйлийн аюулгүй байдалд нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд, аливаа этгээд нь ИНД-71-ийн дагуу тогтоосон аюултай бүсэд жиро-глайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.</p>	<p>аливаа этгээд <a href="#">ИНД-73</a>-т заасан <a href="#">хориотой</a> бүсэд хийн бөмбөлөг, цаасан шувуу, пуужин, агаарын хөлгийн загвар, <a href="#">жиропланер</a> хөөргөх, нисгэхийг хориглоно.</p> <p>(b) НХҮ-ний холбогдох байгууллагаас зөвшөөрөл олгогдоогүй тохиолдолд, аливаа этгээд <a href="#">ИНД-73</a>-т заасан Цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд хийн бөмбөлөг, цаасан шувуу, пуужин, агаарын хөлгийн загвар, <a href="#">жиропланер</a> хөөргөх, нисгэхийг хориглоно.</p> <p>(в) НХҮ-ний холбогдох байгууллагаас зөвшөөрөл олгогдоогүй тохиолдолд, аливаа этгээд <a href="#">ИНД-73</a>-т заасан аюултай бүсэд хийн бөмбөлөг, цаасан шувуу, пуужин, агаарын хөлгийн загвар, <a href="#">жиропланер</a> хөөргөх, нисгэхийг хориглоно.</p>	<p>-“Хориотой” гэснийг “Хязгаарлалттай” гэж өөрчлөгдсөн.</p> <p>-Заалтын нэр өөрчлөгдсөн. -“ИНД-73” гэснийг “ИНД-71” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>101.9. Нам өндрийн нислэгийн зоон</b> <a href="#">ИНД-71</a>-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн зоонд, аливаа этгээд нь дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> <li>(1) хүнгүй агаарын хөлөг;</li> <li>(2) цаасан шувуу;</li> <li>(3) пуужин;</li> <li>(4) жиро-глайдер;</li> <li>(5) парасэйл.</li> </ol>	<p><b>101.9. Хязгаарлалттай бүс</b> (a) <a href="#">ИНД-73</a>-т заагдсан хязгаарлалттай бүс, эсхүл агаарын хөлгийн хэт нам өндрийн нислэгийн бүсэд хийн бөмбөлөг, цаасан шувуу, пуужин, агаарын хөлгийн загвар, жиропланер зэргийг нисгэх, хөөргөхийг хориглоно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан -Заалтын нэр өөрчлөгдсөн. -“ИНД-73” гэснийг “ИНД-71” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>101.11. Хяналттай агаарын зай</b> Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад тохиолдолд, тухайн агаарын зайг хариуцсан НХҮ-ын нэгжээс урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр, аливаа этгээд нь дараах төхөөрөмжөөр хяналттай агаарын зайд үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> <li>(1) <a href="#">хүнгүй агаарын хөлөг</a>;</li> <li>(2) <a href="#">цаасан шувуу</a>;</li> <li>(3) <a href="#">пуужин</a>;</li> <li>(4) <a href="#">жиро-глайдер</a>;</li> <li>(5) <a href="#">парасэйл</a>.</li> </ol>	<p><b>101.11. Хяналттай агаарын зай</b> (a) НХҮ-ний холбогдох байгууллагаас зөвшөөрөл олгогдоогүй тохиолдолд, аливаа этгээд хяналттай агаарын зайд хийн бөмбөлөг, цаасан шувуу, пуужин, агаарын хөлгийн загвар, жиропланер хөөргөх, нисгэхийг хориглоно.</p>	<p>-Amend.6-аар нэмэгдсэн</p>
<p><b>101.12. Агаарын зайн мэдлэг</b> (a) Энэ зүйл нь дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа</p>	<p><b>101.13. Аюултай үйл ажиллагааг хориглох</b> (a) Агаарын хөлөг, хүн, эсхүл бусдын өмч хөрөнгөд хохирол</p>	

<p>эрхлэх этгээдэд хамаарна:</p> <ol style="list-style-type: none"> <li>(1) хүнгүй агаарын хөлөг;</li> <li>(2) цаасан шувуу;</li> <li>(3) пуужин;</li> <li>(4) <a href="#">жиро-глайдер</a>;</li> <li>(5) <a href="#">парасэйл</a>.</li> </ol> <p>(b) <a href="#">Энэ зүйлд хамаарах этгээд нь дараах үүрэгтэй:</a></p> <ol style="list-style-type: none"> <li>(1) <a href="#">нислэг бүрийн өмнө тухайн этгээдийг ИНД-71-ийн дагуу тогтоосон агаарын зайн ангилал болон үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөсөн бүсийн холбогдох агаарын зайн хязгаарлалтын талаар мэдэж байгааг бататгах; эсхүл</a></li> <li>(2) <a href="#">тухайн үйл ажиллагааг ИНД-71-ийн дагуу тогтоосон агаарын зайн ангилал болон үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөсөн бүсийн холбогдох агаарын зайн хязгаарлалтын талаар мэдлэгтэй этгээдийн шүүд хяналтад гүйцэтгэх.</a></li> </ol>	<p>учруулж болзошгүй байдлаар хийн бөмбөлөг, цаасан шувуу, пуужин, агаарын хөлгийн загвар, <a href="#">жиропланер</a> хөөргөх, нисгэхийг хориглоно.</p>	<p>-Нэр томьёо өөрчлөгдсөн</p> <p>-Amend.6-аар нэмэгдсэн</p>
<p><b>101.13. Аюул болон эрсдэлийг багасгах</b></p> <p><a href="#">Дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь хүн, өмч хөрөнгө болон бусад агаарын хөлөгт учирч болзошгүй аюулыг багасгах боломжит бүх арга хэмжээг авах үүрэгтэй:</a></p> <ol style="list-style-type: none"> <li>(1) <a href="#">хүнгүй агаарын хөлөг</a>;</li> <li>(2) <a href="#">цаасан шувуу</a>;</li> <li>(3) <a href="#">пуужин</a>;</li> <li>(4) <a href="#">жиро-глайдер</a>;</li> <li>(5) <a href="#">парасэйл</a>.</li> </ol>		<p>-Amend.6-аар нэмэгдсэн</p>
<p><b>101.15. Эд зүйл <a href="#">хаях</a></b></p> <p><a href="#">Дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь хэрэв тухайн үйлдэл нь хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахаар бол, нислэгийн үед аливаа зүйлийг хаяхыг зөвшөөрөхгүй байх үүрэгтэй:</a></p> <ol style="list-style-type: none"> <li>(1) хүнгүй агаарын хөлөг;</li> <li>(2) цаасан шувуу;</li> <li>(3) пуужин;</li> <li>(4) <a href="#">жиро-глайдер</a>;</li> <li>(5) <a href="#">парасэйл</a>.</li> </ol>	<p><b>101.15. Эд зүйлс <a href="#">унагах</a></b></p> <p>(a) Хийн бөмбөлөг, цаасан шувуу, пуужин, агаарын хөлгийн загвар, <a href="#">жиропланер</a> хөөргөх, нисгэх үед хүн, амьтан болон бусдын өмч хөрөнгөнд хохирол учруулж болзошгүй бол тэдгээрээс аливаа эд зүйлс унагаж хаяхыг хориглоно.</p>	<p>-Amend.7-аар нэмэгдсэн</p>

	<b>101.17. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх</b> <b>(а) ИНЕГ-ын дарга нь шаардлагатай тохиолдолд, аливаа этгээдийг энэ дүрмийн шаардлагаас ИНД-11-ийн дагуу чөлөөлж болно.</b>	-Amend.3-аар хасагдсан
<b>В Бүлэг — Аргамжаат бөмбөлөг болон цаасан шувуу</b>	<b>Б БҮЛЭГ. АРГАМЖААТ ХИЙН БӨМБӨЛӨГ БА ЦААСАН ШУВУУ</b>	
<b>101.51. Хамрах хүрээ</b> <u>Энэ Бүлэг нь, аргамжаат бөмбөлөг болон цаасан шувууны үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.</u>	<b>101.51. Нөөц</b>	-Орхигдуулсан
<b>101.53. Аэродромын бүс</b> Аливаа этгээд нь аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар дараах үйл ажиллагаа эрхлэхгүй: (1)аэродромын ашиглагдаж байгаа агаарын хөлгийн хөдөлгөөнт бүс дээр, эсхүл дээгүүр; эсхүл (2) <u>аливаа хөөрч бүүх зурвас, эсхүл хөөрч бүүх зурвасны үргэлжилсэн талбай дээр, эсхүл дээгүүр.</u>	<b>101.53. Аэродромын талбай</b> (а) Аргамжаат хийн бөмбөлөг, эсхүл цаасан шувууг дараах талбайд хөөргөхийг хориглоно: 1/ агаарын хөлгийн идэвхитэй хөдөлгөөнтэй аэродромын талбай, <b>2/ хөөрч бүүх зурвасны талбай.</b>	-Орчуулга, найруулга зассан -“талбай” гэснийг “бүс” гэж өөрчлөгдсөн
<b>101.55. Аэродромын хил хязгаар</b> Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааны хувьд, дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь аэродромын хил хязгаараас 4 км дотор аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар үйл ажиллагаа эрхлэхгүй: (1)тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь газрын түвшнээс дээш (AGL) 120 м-ээс (400 ft дээш хэтрэхгүй байх; (2)тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь үүлнээс доош 120 м-ээс (400 ft) багагүй босоо зайд тогтож байх; (3)тухайн алсын барааны харагдац 4 км-ээс багагүй байх; (4)хэрэв тухайн аэродром нь <u>хяналттай аэродром бол</u> , НХУ-аас зөвшөөрөл авсан байх; (5) <u>хэрэв аэродром нь хяналтгүй аэродром бол, тухайн үйл ажиллагааг аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн байх.</u>	<b>101.55. Аэродромын хил хязгаар</b> (а) Аливаа этгээдийг дор дурьдснаас бусад тохиолдолд, аэродромын хил хязгаараас 4км-ээс дотогш зайд аргамжаат хийн бөмбөлөг, цаасан шувуу хөөргөхийг хориглоно:  1/ хийн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь газрын гадаргуугаас дээш 120 м (400 фут)-ээс дээш хөөрөхгүй бол;  2/ хийн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь үүлнээс доош 120 м (400 фут)- ээс доошгүй зайд тогтож байвал;  3/ хэвтээ чиглэл дэх алсын барааны харагдац 4 км-ээс багагүй бол; 4/ аэродромын Нислэгийн хөдөлгөөний удирдлага /НХУ/-аас зөвшөөрсөн бол.	-Үйл ажиллагааны хязгаарлалтын шаардлага нэмэгдсэн.
<b>101.57. Агаарын зай</b> (а) <u>Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад тохиолдолд</u> , аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар AGL 120 м-ээс (400 ft) дээш өндөрт үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:	<b>101.57. Агаарын зай</b> (а) Аргамжаат хийн бөмбөлөг, цаасан шувууг 120 м (400 фут)-ээс дээш өндөрт хөөргөх этгээд нь:	-Орчуулга, найруулга зассан

<p>(1) <a href="#">ИНД-71</a>-ийн дагуу, тухайн зорилгоор тогтоосон аюултай бүсэд үйл ажиллагаа эрхлэх; эсхүл</p> <p>(2) энэ зүйлийн (b)-д заасан хязгаарлалтын дагуу үйл ажиллагаа эрхлэх.</p> <p>(b) Аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар аюултай бүсийн гадна AGL 120 м-ээс (400 ft) дээш өндөрт үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дараах нөхцөлийг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь аэродромын хил хязгаараас 4 км-ээс хол зайд байнга байгааг;</p> <p>(2) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь G-ангиллын агаарын зайд байнга байгааг;</p> <p>(3) тухайн цаасан шувууны жин 15 кг-аас хэтрээгүйг;</p> <p>(4) бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь үүлнээс доош 120 м-ээс (400 ft) доошгүй босоо зайд байнга байгааг;</p> <p>(5) алсын барааны харагдац 4 км-ээс багагүй байгааг;</p> <p>(6) тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24 цагаас доошгүй хугацааны өмнө NOTAM-д дараах мэдээллийг өгснийг:</p> <p>(i) тэдний нэр, хаяг, утасны дугаар;</p> <p>(ii) тухайн үйл ажиллагаа эрхлэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;</p> <p>(iii) тухайн <a href="#">аргамжаат бөмбөлөг</a>, эсхүл цаасан шувууны хэмжээ, давамгайлсан өнгийг багтаасан товч тайлбар;</p> <p>(iv) тухайн аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувууны жин;</p> <p>(v) тухайн <a href="#">аргамжаат бөмбөлөг</a>, эсхүл цаасан шувуугаар үйл ажиллагаа эрхлэх өндөр.</p>	<p>1/ энэ төрлийн үйл ажиллагаанд зориулагдсан, <a href="#">ИНД-73</a>-д заагдсан аюултай бүсэд хөөргөнө; эсхүл</p> <p>2/ энэ зүйлийн (б)-д заасан хязгаарлалтыг мөрдөнө.</p> <p>(б) Аргамжаат хийн бөмбөлөг, эсхүл цаасан шувууг 120 м (400 фут)-ээс дээш өндөрт, аюултай бүсийн гадна хөөргөж байгаа аливаа этгээд дараах шаардлагыг мөрдөнө:</p> <p>1/ аливаа аэродромын хил хязгаараас 4 км-ээс цааш зайд хөөргөх;</p> <p>2/ G ангиллын агаарын зайд хөөргөх;</p> <p>3/ цаасан шувууны жин 15 кг-аас хэтрэхгүй байх;</p> <p>4/ хийн бөмбөлөг, цаасан шувууг үүлнээс доош 120 м (400 фут)-ээс доошгүй зайд хөөргөх;</p> <p>5/ хэвтээ чиглэл дэх алсын барааны харагдац 4 км-ээс багагүй байх;</p> <p>6/ тухайн үйл ажиллагааг явуулахаас 24 цагийн өмнө NOTAM-д дараах мэдээллийг өгсөн байх:</p> <p>6.1 нэр, хаяг, утасны дугаар;</p> <p>6.2 үйл ажиллагаа явуулах өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;</p> <p>6.3 <a href="#">хийн бөмбөлөг</a>, цаасан шувууны хэмжээ, өнгө болон бусад мэдээлэл;</p> <p>6.4 цаасан шувууны жин;</p> <p>6.5 <a href="#">хийн бөмбөлөг</a>, цаасан шувууг хөөргөх өндөр.</p>	<p>-“ИНД-73” гэснийг “ИНД-71” гэж өөрчилсөн.</p> <p>-“хийн бөмбөлөг” гэснийг “аргамжаат бөмбөлөг” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>101.59. Шөнийн үйл ажиллагаа</b> Аливаа этгээд нь аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.</p>	<p><b>101.59. Шөнийн цагт хөөргөх</b> (а) Аргамжаат хийн бөмбөлөг болон цаасан шувууг шөнийн цагт хөөргөхийг хориглоно.</p>	
<p><b>101.61. Бөмбөлөг аргамжих уяаны тэмдэглэгээ</b> AGL 45 м-ээс (150 ft) ихгүй өндрөөс эхлэн бөмбөлгийн аргамжааны дагуу 15 м тутамд, 1.8 км-ээс (1 nm) хол зайнаас <a href="#">харагдахуйц өнгөт тууз, эсхүл дарцаг бэхэлснээс бусад тохиолдолд аливаа этгээд нь өдрөөр аргамжаат</a></p>	<p><b>101.61. Хийн бөмбөлгийг аргамжих уяаны тэмдэглэгээ</b> (а) <a href="#">Хийн бөмбөлгийг</a> аргамжих уяан дээр, газрын гадаргуугаас дээш 45 м (150 фут)-ээс дээшгүй өндрөөс эхлэн 15 м тутамд 1,8 км-ийн зайнаас <a href="#">харагдахуйц тод өнгийн зүйл бэхэлж тэмдэглэнэ.</a></p>	<p>-“тод өнгийн зүйл” гэснийг өнгөт “тууз, эсхүл дарцаг” гэж өөрчлөгдсөн -“Өдрөөр аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа</p>

<a href="#">Бөмбөлгөөр</a> үйл ажиллагаа эрхлэхгүй.		эрхлэхгүй” гэж нэмж оруулсан
<b>101.63. Бөмбөлгийн хийг хурдан гаргах төхөөрөмж</b> Бөмбөлөг аргамжаанаас алдуурсан үед хийг автоматаар, хурдан гаргах төхөөрөмжөөр тоноггноос бусад тохиолдолд аливаа этгээд нь аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.	<b>101.63. Хийн бөмбөлгийн хийг гаргах төхөөрөмж</b>  (a) Хийн бөмбөлөг нь аргамжаанаас салах тохиолдолд хийг автоматаар гаргах төхөөрөмжөөр тоноглогдоогүй бол уг бөмбөлгийг хөөргөхийг хориглоно.	-Орчуулга найруулга засагдсан
<b>101.65. Бөмбөлөг алдуурах</b> Бөмбөлөг аргамжаанаас алдуурахад түүний хийг гаргах хэрэгсэл зохих ёсоор ажиллаагүй бол аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь ойролцоох НХҮ-ний нэгжид дараах мэдээллийг яаралтай мэдээлнэ: (1) тухайн бөмбөлгийн анхны байрлал; (2) тухайн бөмбөлөг алдуурсан цаг; (3) тухайн бөмбөлгийн тооцоолсон нислэгийн зам.	<b>101.65. Хийн бөмбөлөг алдуурах</b> (a) Хийн бөмбөлөг аргамжаанаас алдуурч, хийгээ алдалгүй хөөрөх тохиолдолд хийн бөмбөлгөөр үйл ажиллагаа явуулж байгаа этгээд нь ойролцоох НХҮ-ний төвд дараах мэдээллийг яаралтай өгнө:  1/ хийн бөмбөлөг байрлаж байсан газар; 2/ аргамжаанаас алдуурсан цаг; 3/ бөмбөлгийн хөөрөх чиглэлийн баримжаа.	-Орчуулга найруулга зассан
<b>С Бүлэг — Чөлөөт бөмбөлөг</b>	<b>В БҮЛЭГ. ЧӨЛӨӨТ <u>ХИЙН</u> БӨМБӨЛӨГ</b>	
<b>101.101. Хамрах хүрээ</b> <a href="#">Энэ Бүлэг нь чөлөөт бөмбөлгийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.</a>	<b>101.101. Нөөц</b>	-Орхигдуулсан
<b>101.103. Цаг уурын хязгаарлалт</b> Холбогдох НХҮ-ээс зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа этгээд нь 18 000 м-ийн (60 000 ft) <a href="#">даралтын түвшинд, эсхүл түүнээс доош түвшнийг</a> нэвтлэн хүнд чөлөөт бөмбөлгөөр дараах нөхцөлд үйл ажиллагаа эрхлэхгүй: (1) <a href="#">4 - 8 октантаас</a> дээш үүлшилтэй, эсхүл үүлэнд далдлагдсан аюултай үзэгдэл байгаа; (2) алсын барааны харагдац 8 км-ээс бага; (3) бусад улсын нутаг дэвсгэрийн агаарын зайд <a href="#">зөвшөөрөлгүй</a> нэвтэрч болзошгүй.	<b>101.103. Цаг агаарын хязгаарлалт</b> (a) НХҮ-ний байгууллагаас зөвшөөрөөгүй бол аливаа этгээд чөлөөт хийн бөмбөлгийг даралтаар илэрхийлэгдэх 18000 м (60000 фут)-ээс <a href="#">дээшгүй өндөрт</a> , дараах тохиолдолд хөөргөхийг хориглоно:  1/ <a href="#">5-8 октант</a> (BKN, OVC) үүлтэй бол;  2/ хэвтээ чиглэл дэх алсын барааны харагдац 8 км-ээс бага бол;  3/ хил залгаа улсын агаарын зайд нэвтэрч болзошгүй бол.	-“5-8 октант” гэснийг “4-8 октантаас дээш” гэж өөрчлөгдсөн -Зөвшөөрөлгүй гэсэн шаардлага нэмэгдсэн
<b>101.105. Үйл ажиллагааны хязгаарлалт</b> <a href="#">Хүнд, эсхүл дундаж чөлөөт бөмбөлөг нь дараах байдлаар нисэхээр бол аливаа этгээд түүнийг суллан тавихгүй:</a> (1) хот, сум, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр 300 м-ээс (1000 ft) доош өндөрт; эсхүл (2) <a href="#">олон хүн цугларсан задгай талбайн дээгүүр.</a>	<b>101.105. Үйл ажиллагааны хязгаарлалт</b> <b>(a) Ачаа дүүжилсэн хийн бөмбөлгийг дараах нутаг дэвсгэр дээгүүр хөөргөхийг хориглоно:</b> 1/ хүн ам шигүү суурьшсан хот суурингийн дээр 300 м (1000 фут)-ээс доош өндөрт; 2/ <a href="#">хүн олноор цугларсан задгай талбай, газар дээгүүр.</a>	-Орчуулга, найруулга зассан.
<b>101.107. Төхөөрөмж</b> Аливаа этгээд дараахаас бусад тохиолдолд хүнд чөлөөт	<b>101.107. Тоног төхөөрөмж</b> (a) Дараах шаардлагыг хангаагүй чөлөөт хийн бөмбөлгийг	-Орчуулга найруулга зассан

<p>бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:</p> <p>(1) дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байх:</p> <p>(i) нэгнээсээ үл хамааран автоматаар, эсхүл телеметрийн удирдлагаар ажилладаг, <a href="#">ашигт ачааг</a> нислэгт салгах 2-оос доошгүй төхөөрөмж, эсхүл системээр;</p> <p>(ii) ADS-B системээр, хэрэв тухайн агаарын бөмбөлөг нь Монгол Улсын FIR-д ИНД-71-ийн дагуу тогтоосон FL 245-аас дээш транспондер шаардлагатай хяналттай агаарын зай үйл ажиллагаа гүйцэтгэх бол.</p> <p>(iii) тогтоосон кодоор тасралтгүй ажилладаг, эсхүл хяналтын төвөөс шаардлагатай үед асааж болдог түвшин мэдээлэх чадвартай ажиглалтын транспондероор, хэрэв тухайн агаарын бөмбөлөг нь Монгол Улсын FIR-д ИНД-71-ийн дагуу тогтоосон FL 245-аас доош транспондер шаардлагатай хяналттай агаарын зай үйл ажиллагаа гүйцэтгэх бол;</p> <p>(2) тэг даралттай полиэтилен бөмбөлгийн хувьд, нэгнээсээ үл хамааран ажилладаг, хоёроос доошгүй арга, систем, хэрэгсэл, эсхүл тэдгээрийг нэгтгэсэн, нислэгийг таслан зогсоох төхөөрөмжтэй байх;</p> <p>(3) бөмбөлгийн бүрхүүл нь дараах байдлаар тоноглогдсон байх:</p> <p>(i) радарын дохиог ойлгогч нэгээс доошгүй хэрэгслээр; эсхүл</p> <p>(ii) <a href="#">2 700 - 2 900 мГц</a> давтамжийн хүрээнд ажиллаж байгаа газрын радарт эхо үүсгэх радар ойлгогч материалаар.</p>	<p>хөөргөхийг хориглоно:</p> <p>1/ тоног төхөөрөмжийн хувьд:</p> <p>1.1 бие биеэсээ үл хамааран автоматаар, эсхүл телеметрийн аргаар ажилладаг, хөөрөлтийг зогсоох хоёр төхөөрөмжтэй байх; ба</p> <p>1.2 тухайн нутаг дэвсгэрт газрын хоёрдогч радиолокаторын төхөөрөмж /SSR/ ашигладаг бол өндөр илтгэгч хариулагчтай байх ба энэ нь таних код дээр тогтмол ажилладаг, эсхүл түүнийг шаардлагатай үед замын дагуух станцаас асаах боломжтой байх;</p> <p>2/ тэг даралттай полиэтилен бөмбөлгийн хувьд, бие биеэсээ үл хамааралтай ажилладаг, хөөрөлтийг зогсоох хоёр төхөөрөмж, систем, эсхүл аргатай байх;</p> <p>3/ бөмбөлөг нь:</p> <p>3.1 радарын дохиог тусган ойлгох төхөөрөмжөөр тоноглогдсон байх, эсхүл</p> <p>3. <a href="#">2 200 мГц- 2700</a> мГц давтамжийн радарын дохиог ойлгох чадвартай материалаар тоноглогдсон байх.</p>	<p>-“2 200 мГц- 2700 мГц” гэснийг “2 700 - 2 900МГц” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>101.109. Нислэгийг таслан зогсоох</b></p> <p>Хүнд бөмбөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа аливаа этгээд нь, дараах нөхцөлд тухайн нислэгийг таслан зогсоохоор 101.107(1)(i) болон (2)-т шаардсан зориулалтын таслан зогсоох хэрэгслийг ажиллуулна:</p> <p>(1) <a href="#">цаг уурын</a> нөхцөл 101.103-т зааснаас муудсан бол; эсхүл</p> <p>(2) цаашдын үйл ажиллагаа нь бусад нислэгийн хөдөлгөөн, эсхүл гадаргуу дээр байгаа хүн, өмч хөрөнгөд аюул учруулахаар бол; эсхүл</p> <p>(3) бусад улсын нутаг дэвсгэрийн агаарын зайд</p>	<p><b>101.109. Үйл ажиллагааг зогсоох</b></p> <p>(а) Дор дурдсан нөхцөлд, ачаа дүүжилсэн хийн бөмбөлгийн хөөрөлтийг энэ дүрмийн 101.107ийн 1/-ийн 1.1 болон 2/-т заасан төхөөрөмжийг ажиллуулж зогсооно:</p> <p>1/ <a href="#">цаг агаарын</a> нөхцөл нь энэ дүрмийн 101.103-д заасан нөхцөлийг хангахгүй бол;</p> <p>2/ хөөрөх үйл ажиллагааг үргэлжлүүлэх нь агаар дахь нислэгийн аливаа хөдөлгөөнд, эсхүл газар дээрх хүмүүс, өмч хөрөнгөд хохирол учруулах аюултай бол;</p> <p>3/ хил залгаа улсын агаарын зайд нэвтэрч болзошгүй бол.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

<p><a href="#">зөвшөөрөлгүй</a> нэвтэрч болзошгүй бол.</p>		
<p><b>101.111. Шөнийн үйл ажиллагаа</b>  Бөмбөлөг, түүнд <a href="#">бэхэлсэн хэрэгсэл</a> болон <a href="#">дүүжилсэн ашигт ачаа</a> нь тухайн үйл ажиллагааны <a href="#">үед салах эсэхээс үл хамааран</a>, бөмбөлөг тус бүрийг дараах шаардлага хангасан гэрлээр тоногсноос бусад тохиолдолд аливаа этгээд хүнд чөлөөт бөмбөлгөөр 18 000 м-ээс (60 000 ft) доош даралтын түвшинд шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:  (1) 9 км-ээс (5 nm) багагүй зайд харагдахуйц байх;  (2) минутад 40-100 үечлэлийн анивчих давтамжтай байх;  (3) гэрэл нь өөрийн тэжээлийн эх үүсгүүртэй байх:</p>	<p><b>101.111. Шөнийн цагт хөөргөх</b>  (а) Хийн бөмбөлөг, түүний тоноглол, дүүжилсэн ачаа тус бүр нь дараах шаардлагыг хангасан гэрэлтүүлэггүй бол шөнийн цагт, даралтаар илэрхийлэгдэх 18000 м (60000 фут)- ээс дээш өндөрт хөөргөхийг хориглоно:   1/ 9 км (5 nm)-ээс багагүй зайнаас энгийн нүдээр харагдахуйц;  2/ анивчих давтамж нь 1 минутад 40-100 удаа байх;  3/ гэрэл бүр тус тусдаа цахилгаан үүсгүүртэй байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>101.113. Сүүлэн антен</b>  <a href="#">Дараах өнгөт дарцаг, эсхүл түүз үяж бэхэлснээс бусад тохиолдолд, аливаа этгээд аль ч хэсгээр нь таслахад 230 Ньютоноос их хүч шаарддаг сүүлэн антенаар тоногдсон чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:</a>  (1) <a href="#">хоорондоо 15 м-ээс ихгүй үечлэлтэй бэхлэгдсэн;</a>  (2) <a href="#">1.8 км-ээс (1 nm) багагүй зайд харагдахуйц.</a></p>	<p><b>101.113. Нөөц</b></p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p><b>101.115. Дүүжин хэрэгсэл</b>  <a href="#">Хурц өнгөтэй задгай шүхрээс бусад дүүжин хэрэгсэл нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд аливаа этгээд 15 м-ээс үрт дүүжин хэрэгслээр тоногдсон хүнд чөлөөт бөмбөлгөөр 18 000 м-ээс (60 000 ft) доош даралтын түвшинд, өдрөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:</a>  (1) <a href="#">алсаас харагдац сайтай эсрэг өнгөөр хосолсон өнгөтэй байх; эсхүл</a>  (2) <a href="#">1.8 км-ээс (1 nm) багагүй зайд харагдахуйц өнгөт түүз, эсхүл дарцаг бэхэлсэн байх.</a></p>	<p><b>101.115. Нөөц</b></p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p><b>101.117. Хөөргөлтийн өмнөх мэдээлэл</b>  (а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь хөөргөхөөр <a href="#">төлөвлөснөөс</a> 24 цагаас доошгүй хугацааны өмнө дараах мэдээллийг NOTAM-д хүргүүлээгүй бол, <a href="#">дундаж, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгийг</a> хөөргөхгүй:  (1) тэдний нэр, утасны дугаар;  (2) тухайн бөмбөлгийн таних тодорхойлолт, эсхүл</p>	<p><b>101.117. Хөөрөлтийн өмнөх мэдээлэл</b>  (а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, хийн бөмбөлгийг хөөргөхөөс 24 цагийн өмнө дараах мэдээллийг NOTAM-д ирүүлсэн байна:   1/ бөмбөлөг хөөргөх хүний нэр, утасны дугаар;  2/ хийн бөмбөлгийн таних тэмдэг буюу кодолсон нэр;</p>	<p>-Бөмбөлгийн хэмжээ заагдсан.   -Орчуулга, найруулга зассан.</p>



<p>төслийн кодын нэр;</p> <p>(3) тухайн бөмбөлгийн ангилал болон дараах мэдээллийг багтаасан тайлбар:</p> <p>(i) бөмбөлгийн урт болон диаметр;</p> <p>(ii) дүүжин хэрэгслийн урт;</p> <p>(iii) ашигт ачааны жин;</p> <p>(iv) <a href="#">сүүлэн антены урт</a>;</p> <p>(4) хэрэв хамааралтай бол, SSR-ын код;</p> <p>(5) тухайн хөөргөх <a href="#">талбайн</a> байрлал;</p> <p>(6) тухайн тооцоот хөөргөх цаг, эсхүл олон дахин хөөргөх бол, эхлэх ба дуусах цаг;</p> <p>(7) тухайн хөөргөх бөмбөлгийн тоо, олон дахин хөөргөх бол, хөөргөлт хоорондын давтагдах хугацаа;</p> <p>(8) тухайн хөөрөх чиглэлийн баримжаа;</p> <p>(9) тухайн аяллын түвшинд хүрэх, эсхүл 18 000 м-ийн (60 000 ft) даралтын түвшнийг огтлох тооцоот цагийн аль багыг;</p> <p>(10) тухайн <a href="#">төлөвлөсөн аяллын түвшин</a> (даралтын түвшнээр);</p> <p>(11) <a href="#">тухайн нислэг</a> үргэлжлэх <a href="#">төлөвлөсөн</a> хугацаа;</p> <p>(12) <a href="#">газрын гадаргууд буух</a> тооцоот цаг болон байрлал.</p> <p>(b) Дундаж эсхүл хүнд чөлөөт бөмбөлгийг, цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл шаарддаг нарны, эсхүл сансрын идэвхжлийн нөлөөллийг судлах зорилгоор хөөргөх тохиолдолд аливаа этгээд энэ зүйлийн (a)-д заасан мэдээллийг бөмбөлөг хөөргөх тооцоот цагаас 30 минутаас доошгүй хугацааны өмнө мэдэгдэж болно.</p> <p>(c) Энэ зүйлийн (a)-ийн дагуу өгсөн мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд, бөмбөлөг хөөргөх этгээд нь тухайн өөрчлөлтийг бөмбөлөг хөөргөхөөр төлөвлөсөн цагаас 6-аас доошгүй хугацааны өмнө NOTAM-д мэдэгдэнэ.</p>	<p>3/ хийн бөмбөлгийн тодорхойлолт:</p> <p>3.1 бөмбөлгийн урт ба диаметр;</p> <p>3.2 дүүжилсэн ачааны жин.</p> <p>4/ хэрэв шаардлагатай бол, хоёрдогч радиолокатор /SSR/-ын код;</p> <p>5/ хөөргөх <a href="#">цэгийн</a> байршил;</p> <p>6/ хөөргөх цаг буюу олон дахин хөөргөх бол эхлэх ба дуусах цаг;</p> <p>7/ хөөргөх бөмбөлгийн тоо, хөөргөлт хоорондын хугацаа;</p> <p>8/ хөөргөх чигийн баримжаа;</p> <p>9/ даралтаар илэрхийлэгдэх 18000 м (60000 фут)-ийн өндөрт хүрэх буюу өнгөрөх хугацаа;</p> <p>10/ <a href="#">хөөрөлтийн тооцоот өндөр</a>;</p> <p>11/ хөөрөлт үргэлжлэх хугацаа;</p> <p>12/ газарт буух тооцоот цаг, байрлал;</p> <p>(b) Хийн бөмбөлгийг судалгааны зорилгоор хөөргөх тохиолдолд, энэ зүйлийн (a)-д заасан мэдээллийг бөмбөлөг хөөргөхөөсөө 30 минутаас доошгүй хугацааны өмнө НХҮ– ний холбогдох байгууллагад өгнө.</p> <p>(в) Энэ зүйлийн (a)-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд, өөрчлөлтийн талаар бөмбөлөг хөөргөхөөс 6 цагаас доошгүй хугацааны өмнө NOTAM–д мэдэгдэнэ.</p>	<p>-“тухайн төлбөрт ачааны жин”, “ сүүлэн антены урт” заалтуудыг нэмж оруулсан.</p>
<p><b>101.119. Хөөргөлтийн <a href="#">мэдээлэл</a></b>  <a href="#">Дундаж эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр</a> үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь бөмбөлгийг хөөргөсний дараа <a href="#">хамгийн ойрын</a> НХҮ-ний нэгжид дараах мэдээллийг нэн даруй мэдээлнэ:</p>	<p><b>101.119. Хөөрөлтийн <a href="#">тухай мэдээ</a></b>  (a) <a href="#">Хийн бөмбөлөгийг хөөргөсөн этгээд, бөмбөлөгийг</a> хөөргөсний дараа НХҮ-ний холбогдох байгууллагад дараах мэдээг нэн даруй дамжуулна:</p>	<p>-Орчуулга найруулга зассан  - “Хийн бөмбөлөгийг хөөргөсөн этгээд,</p>

<p>(1) тухайн бөмбөлгийн нислэгийн таних тодорхойлолт;  (2) тухайн хөөргөх талбай;  (3) тухайн хөөргөлтийн <u>бодит</u> цаг;  (4) 18 000 м-ийн (60 000 ft) <u>даралтын түвшнийг огтлох тооцоот цаг, эсхүл хэрэв аяллын түвшин</u> нь 18 000 м-ийн (60 000 ft) өндөрт, эсхүл түүнээс доош бол, хүрэх <u>тооцоот</u> цаг болон <u>тооцоот</u> байрлал;  (5) 101.117(а)(7), эсхүл (8)-ын дагуу өгсөн мэдээлэлд орсон өөрчлөлт.</p>	<p>1/ хийн бөмбөлөгийн таних тэмдэг буюу кодолсон нэр;  2/ хөөргөсөн газар;  3/ хөөргөсөн цаг;  4/ даралтаар илэрхийлэгдэх 18000 м (60000 фут)-ийн өндөрт хүрэх цаг, хугацаа, байрлал;  5/ энэ дүрмийн 101.117-гийн (а)-гийн 7/, 8/-ын дагуу өгөгдсөн мэдээлэлд аливаа өөрчлөлт орсон бол тухайн өөрчлөлт.</p>	<p>бөмбөлөгийг” гэснийг “Дундаж эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр” гэж өөрчлөгдсөн</p>
<p><b>101.121. <u>Цуцлалтын мэдээлэл</u></b>  Энэ дүрмийн 101.117-гийн дагуу хөөргөлтийн өмнөх мэдээлэл хүргүүлсэн этгээд нь <u>хөөргөх үйл ажиллагааг цуцалсан бол</u>, НХҮ-ний нэгжид тухайн <u>цуцлалтын</u> талаар нэн даруй мэдээлнэ.</p>	<p><b>101.121. Мэдээллийг хүчингүй болгох</b>  (а) Энэ дүрмийн 101.117-гийн дагуу <u>өгөгдсөн мэдээллийг хүчингүй болгох бол</u> НХҮ-ний зохих байгууллагад энэ талаар нэн даруй мэдэгдэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>101.123. <u>Бөмбөлгийн байршлыг илтгэх</u></b>  <u>Дундаж эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр</u> үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь:  (1) НХҮ-ний нэгжээс өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд, хоёр цаг тутамд тухайн бөмбөлгийн чиглэлийг хянаж, түүний <u>байршлыг</u> бүртгэнэ;  (2) НХҮ-ний нэгжээс хүссэн бөмбөлгийн байршлын мэдээллийг <u>дамжуулна</u>;  (3) нислэгийн аливаа хоёр цагийн хугацаанд бөмбөлгийн байршлын мэдээлэл бүртгэгдээгүй тохиолдолд, ойролцоох НХҮ-ний нэгжид дараах мэдээллийг нэн даруй мэдээлнэ:  (i) хамгийн сүүлд бүртгэгдсэн байршил;  (ii) баримжаат траекторт орсон өөрчлөлт;  (4) тухайн бөмбөлгийн замын хяналт эргэн тогтоогдвол, НХҮ-ний нэгжид нэн даруй мэдээлнэ.</p>	<p><b>101.123. <u>Хийн бөмбөлөгийн байрлалын бүртгэл</u></b>  (а) <u>Хийн</u> бөмбөлөг хөөргөгч этгээд нь:  1/ НХҮ-ний байгууллагаас өөрөөр шаардаагүй бол, хөөргөсөн бөмбөлгийн байрлалыг хоёр цаг тутамд бүртгэж, бөмбөлөгийн нислэгийн чиглэлийг хянана;  2/ НХҮ-ний байгууллагаас хүссэний дагуу бөмбөлөгийн байрлалын талаар мэдээлнэ;  3/ бөмбөлөгийн байрлалыг хоёр цаг тутам бүртгэх боломжгүй бол ойролцоох НХҮ-ний байгууллагад даруй дараах зүйлийг мэдэгдэнэ  3.1 хамгийн сүүлд бүртгэгдсэн байрлал;  3.2 урьдчилан тогтоосон траекториосоо хэр зэрэг зөрж байгаа байдал.  4/ бөмбөлөгийн зам, чиглэлийг дахин тогтоосон даруйдаа НХҮ-ний байгууллагад мэдэгдэнэ.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>101.125. <u>Өндөр алдалтын өмнөх байршлыг илтгэх</u></b>  Дундаж эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах мэдээллийг, <u>төлөвлөсөн өндөр алдалт эхлэхээс</u> нэгээс доошгүй цагийн өмнө ойролцоох НХҮ-ний нэгжид өгнө:  (1) тухайн байгаа газар зүйн байршил;  (2) тухайн байгаа <u>түвшин</u>;</p>	<p><b>101.125. <u>Хийн бөмбөлөг газардахаас өмнө өгөх мэдээлэл</u></b>  (а) Хийн бөмбөлгийн үйл ажиллагаа явуулж байгаа аливаа этгээд нь дараах мэдээллийг, <u>хийн бөмбөлөг газардахаас</u> 1 цагийн өмнө ойролцоох НХҮ-ний байгууллагад өгнө:  1/ газар зүйн бодит байрлал;  2/ хөөрч байгаа <u>бодит өндөр</u>;</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>



<p>ажиллагаа гүйцэтгэхгүй бол.  <u>(с) Аэродромын хил хязгаараас 4 - 8 км-ийн хоорондох зайд аливаа этгээд нь AGL 120 м-ээс (400 ft) дээш өндөрт пуужингаар үйл ажиллагаа гүйцэтгэхгүй</u></p>		
<p><b>101.157. Цаг уурын хязгаарлалт</b>  (а) Дараах нөхцөлд аливаа этгээд пуужингаар аль ч түвшинд үйл ажиллагаа гүйцэтгэхгүй:  (1) <u>4 - 8 октантаас дээш үлшилтэй, эсхүл үүлэнд далдлагдсан аюултай үзэгдэл байгаа;</u>  (2) алсын барааны харагдац 8 км-ээс бага;  (б) Аливаа этгээд пуужингаар үүл рүү үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.</p>	<p><b>101.157. Цаг агаарын хязгаарлалт</b>  (а) Цаг агаарын дараах нөхцөлд пуужингийн загвар хөөргөхийг хориглоно:  <u>1/ 5-8 октант (BKN, OVC) үүлтэй бол;</u>  2/ алсын барааны харагдац 8 км-ээс бага бол.  (б) Пуужингийн загварыг үүл рүү чиглүүлж хөөргөхийг хориглоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>
<p><b>101.159. Шөнийн үйл ажиллагаа</b>  <u>Аливаа этгээд том загвар пуужингаас бусад пуужингаар шөнөөр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.</u></p>		<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p><b>101.161. Хөөргөлтийн өмнөх мэдээлэл</b>  Хөөргөхөөс 24 цагаас доошгүй хугацааны өмнө NOTAM-д дараах мэдээллийг өгснөөс бусад тохиолдолд аливаа этгээд <u>том загвар пуужингаас бусад</u> пуужинг хөөргөхгүй:  (1) тэдний нэр, хаяг, утасны дугаар, эсхүл нэг арга хэмжээнд олон оролцогч байгаа бол, энэ зүйлийн (2), (3) болон (4)-т шаардсан хөөргөлтийн өгөгдлийн тооцоог багтаасан зохицуулах үүрэгтэй тухайн хөөргөх арга хэмжээг удирдаж байгаа этгээдийн нэр, хаяг, утасны дугаар;  (2) хөөргөхөөр <u>төлөвлөсөн</u> пуужингийн тоо;  (3) пуужин бүрийн <u>тооцоот</u> хэмжээ болон <u>тооцоот</u> жин;  (4) пуужин бүрийн хөөрч хүрэх хамгийн их <u>тооцоот түвшин, эсхүл нислэгийн түвшин;</u>  (5) тухайн үйл ажиллагааны байрлал;  (6) тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;  (7) мэдээлэл авч байгаа этгээдийн хүссэн бусад холбогдох мэдээлэл.</p>	<p><b>101.159. Шөнийн цагт хөөргөх</b>  (а) Пуужингийн загварыг шөнийн цагт хөөргөх тохиолдолд пуужинг хөөргөхөөс 24 цагийн NOTAM-д дараах мэдээллийг өгсөн байна:  1/ пуужин хөөргөхөд оролцож байгаа этгээд болон энэ зүйлийн 2/, 3/, 4/-т заасан өгөгдөхүүнийг гаргаж өгсөн этгээдийн нэр, хаяг, утасны дугаар;  2/ хөөргөх пуужингийн тоо;  3/ пуужин тус бүрийн хэмжээ, жин;  4/ пуужин тус бүрийн хөөрөх <u>дээд өндөр;</u>  5/ үйл ажиллагаа явуулах байршил;  6/ үйл ажиллагаа явуулах өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;  7/ мэдээлэл хүлээн авч байгаа этгээдийн шаардсан бусад мэдээлэл.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><b>Е Бүлэг - <u>Алсын удирдлагатай агаарын хөлөг, үтсан удирдлагатай болон чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар</u></b></p>	<p><b>Д БҮЛЭГ. <u>АГААРЫН ХӨЛГИЙН ЗАГВАР</u></b></p>	
<p><b>101.201. Хамрах хүрээ</b>  <u>Энэ дүрмийн 102.21-ийг харгалзан, энэ Бүлэг нь дараах нисдэг төхөөрөмжид хамаарна:</u>  <u>(1)алсын удирдлагатай агаарын хөлөг;</u></p>	<p><b>101.201. Нөөц</b></p>	<p>-Шинэ дүрэм ИНД-102-той уялдуулж өгсөн</p>

<p><u>(2) утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар;</u>  <u>(3) чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар.</u></p>		
<p><b>101.202. Зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллага</b>  <u>Энэ Бүлэгт заасан зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллага гэж алсын удирдлагатай агаарын хөлгийг зохион бүтээх, үйлдвэрлэх, эсхүл үйл ажиллагаа эрхлэх зохих мэдлэг, мэргэшилтэй, эсхүл агаарын зайн хуваарилалт, хязгаарлалтын талаар зохих мэдлэгтэй болон дараах тусгайлан заасан 1, эсхүл хэд хэдэн ажиллагааг гүйцэтгэхийг Дарга зөвшөөрсөн этгээд, эсхүл байгууллагыг хэлнэ:</u></p> <p><u>(1) алсын удирдлагатай агаарын хөлгийн үйл ажиллагааны нисгэгчийн мэргэшил олгох; эсхүл</u>  <u>(2) алсын удирдлагатай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид зааварчилгаа өгөх этгээдийг томилох; эсхүл</u>  <u>(3) NOTAM гаргахад зориулан, алсын удирдлагатай агаарын хөлгийн үйл ажиллагааны талаар нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэх этгээдэд эрх олгох; эсхүл</u>  <u>(4) 15 кг-аас дээш жинтэй, алсын удирдлагатай агаарын хөлөг үйлдвэрлэх, эсхүл модификаци хийх эрх олгох; эсхүл</u>  <u>(5) 15 кг-аас дээш жинтэй, алсын удирдлагатай агаарын хөлөг үйлдвэрлэх ажиллагааг шалгах ба зөвшөөрөх; эсхүл</u>  <u>(6) 15 кг-аас дээш жинтэй, алсын удирдлагатай агаарын хөлгийн үйл ажиллагааг зөвшөөрөх.</u></p>		<p>-Amend.7-оор нэмэгдсэн</p>
<p><b>101.203. Утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар</b>  Аливаа этгээд нь 30 м-ээс урт нэг, эсхүл хэд хэдэн утсан удирдлагын системтэй агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.</p>	<p><b>101.203. Удирдлагатай агаарын хөлгийн загвар</b>  (а) Аливаа этгээдийг, 30 м-ээс дээш урттай, дан буюу давхар холбоос бүхий утсан удирдлагатай агаарын хөлгийн загварыг нисгэхийг хориглоно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>101.205. Аэродром</b>  (а) Аливаа этгээд нь алсын удирдлагатай агаарын хөлөг, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар дараах аэродром дээр, эсхүл түүнээс 4 км дотор үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:  (1) <u>хяналтгүй</u> аэродромд, дараахаас бусад тохиолдолд:</p>	<p><b>101.205. Аэродром</b>  (а) Агаарын хөлгийн загварыг дор дурдсанаас бусад тохиолдолд, дараах аэродромд, эсхүл түүний хил хязгаараас 4 км-ээс дотогш зайд нисгэхийг хориглоно:   1/ нислэгийн хөдөлгөөний <u>удирдлагагүй</u> аэродромд:</p>	<p>-Amend.7-оор нэмэгдсэн  -“<u>удирдлагагүй</u>” гэснийг  “<u>хяналтгүй</u>” гэж өөрчлөгдсөн</p>

- (i) тухайн үйл ажиллагаа нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй хийсэн гэрээний дагуу хийгдэж байгаа бол;
- (ii) чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загварын хувьд, тухайн агаарын хөлгийг ашиглагдаж байгаа хөөрч буух зурвасны салхины дагуу чиглэлд хөөргөх бол;

(iii) алсын удирдлагатай агаарын хөлгийн хувьд:

(A) тухайн агаарын хөлгийг нислэгт байх үед нисгэгч нь дэргэдээ ажиглагчтай байгаа бол;

(B) үйл ажиллагаа эрхлэгч нь Даргаас, AGL 120 м-ээс (400 ft) дээш өндөрт агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, AGL 120 м-ээс (400 ft) дээш өндөрт тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй бол;

(2) хяналттай аэродромд, тухайн үйл ажиллагааг холбогдох НХУ-ын нэгжээс авсан зөвшөөрлийн дагуу гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд;

(3) аэродромд, дараахаас бусад тохиолдолд:

(i) тухайн этгээд нь:

(A) зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас олгосон нисгэгчийн эрх эзэмшигч, эсхүл эрх бүхий нисгэгчийн шууд хяналтад байгаа бол; эсхүл

(B) алсын удирдлагатай агаарын хөлгийн үйл ажиллагааны зааварчилгаа өгөхөөр, зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас томилогдсон этгээдийн шууд хяналтад байгаа бол; эсхүл

(C) ИНД-61, эсхүл ИНД-149-ийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмшигч бол.

(b) Аливаа этгээд нь алсын удирдлагатай агаарын хөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар дараах үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:

(1) аэродромын ашиглагдаж байгаа хөдөлгөөнт бүс дээр, эсхүл дээгүүр; эсхүл

(2) ашиглагдаж байгаа хөөрч буух зурвасны үргэлжилсэн талбай дээр, эсхүл дээгүүр.

(c) Энэ зүйлийн (a) нь дараах, халхлагдсан үйл

1.1 үйл ажиллагаа явуулах талаар аэродром эзэмшигчтэй урьдчилан тохиролцсон;

1.2 чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загварын хувьд, ХБЗ-ны дагуу салхины уруу хөөргөж байгаа ;

1.3 радио удирдлагатай загварын хувьд, газрын гадаргуугаас дээш 120 м (400 фут)-ээс дээшгүй өндөрт нисгэж байгаа ба загварын нислэгийн тухай аэродромд үйл ажиллагаа явуулж байгаа субъектууд мэдэж байгаа бол.

2/ нислэгийн хөдөлгөөний удирдлагатай аэродромд уг үйл ажиллагааг НХУ-ний байгууллагын зөвшөөрөлтэй гүйцэтгэж байгаа бол;

3/ аль ч аэродромын хувьд, тухайн загварыг нисгэж байгаа этгээд нисгэгчийн мэдлэг боловсролтой , эсхүл нисгэгчийн шууд хяналтанд загварыг нисгэж байгаа бол.

(б) Агаарын хөлгийн загварыг дараах тохиолдолд нисгэхийг хориглоно:

1/ агаарын хөлгийн идэвхтэй хөдөлгөөнтэй байгаа аэродромын талбай дээрээс, буюу дээгүүр нь, эсхүл

2/ нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа ХБЗ дээр, буюу дээгүүр нь.

<p>ажиллагаанд хамаарахгүй:</p> <p>(1) тухайн аэродромын хил хязгаарын гадна;</p> <p>(2) тухайн агаарын хөлгийн нислэгийг саатуулах боломжтой хаалтаар тухайн аэродромоос бодит байдлаар тусгаарлагдсан агаарын зайд.</p> <p>(d) Энэ зүйлийн (а)(3) нь чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загварт хамаарахгүй.</p>		
<p><b>101.207. Агаарын зай</b></p> <p>(a) <u>Алсын удирдлагатай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:</u></p> <p>(1) <u>ИНД-71-ийн дагуу аюултай бүсэд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд, дараах агаарын зайд хийгдэх үйл ажиллагаанаас зайлсхийх:</u></p> <p>(i) <u>тухайн агаарын зайд агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрөөгүй этгээдийн дээгүүр;</u></p> <p>(ii) <u>тухайн өмчийг ашиглаж байгаа этгээд, эсхүл өмчийн эзэмшигчээс үрьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, тухайн өмчийн дээгүүр;</u></p> <p>(2) <u>агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа орчны агаарын зайд байгаа бусад агаарын хөлгийг тогтмол ажиглаж байх;</u></p> <p>(3) <u>энэ зүйлийн (с)-гээс бусад тохиолдолд, AGL 120 м-ээс (400 ft) дээш өндөрт агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх.</u></p> <p>(b) <u>Хэрэв дараах нөхцөлд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол, энэ зүйлийн (а) нь тухайн этгээдийг зөвшөөрөл авахыг шаардахгүй:</u></p> <p>(1) <u>зөвшөөрөгдсөн байгууллагын эрхийн хүрээнд;</u></p> <p>(2) <u>хамааралгүй</u></p> <p>(c) Аэродромын хил хязгаараас 4 км-ээс хол зайд, AGL 120 м-ээс (400 ft) дээш өндөрт алсын удирдлагатай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь, тухайн үйл ажиллагааг G ангиллын агаарын зайд тогтмол гүйцэтгэж байгааг бататгах ёстой ба дараах</p>	<p><b>101.207. Агаарын зай</b></p> <p>(a) Аэродромын хил хязгаараас 4 км-ээс гадагш зайд болон газрын гадаргуугаас дээш 120 м (400 фут)-ээс дээш өндөрт, радио удирдлагатай агаарын хөлгийн загвар нисгэж байгаа этгээд нь уг загварыг C, D агаарын зайд нэвтрүүлэхгүй ба дараах шаардлагыг хангана:</p> <p>1/ ИНД-73-аар тодорхойлогдсон аюултай бүсэд загварыг нисгэх;</p>	<p>-Amend.7-оор нэмэгдсэн</p> <p>-Ямар этгээд болохыг тодорхой зааж өгсөн.</p>

<p>үүрэгтэй:</p> <p>(1) <u>ИНД-71</u>-ийн дагуу тухайн зорилгоор тогтоосон аюултай бүс дотор үйл ажиллагаа гүйцэтгэх; эсхүл</p> <p>(2) <u>зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас эрх олгогдсон</u> этгээд нь тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24 цагаас доошгүй хугацааны өмнө дараах мэдээллийг NOTAM гаргах зорилгоор нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээлдэг болохыг бататгах:</p> <p>(i) үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, хаяг, утасны дугаар;</p> <p>(ii) санал болгосон үйл ажиллагааны байрлал;</p> <p>(iii) санал болгосон үйл ажиллагааг гүйцэтгэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;</p> <p>(iv) тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд санал болгосон, AGL максимум өндөр.</p>	<p>2/ загварыг нисгэхээс 24 цагийн өмнө NOTAM–д дараах мэдээллийг хүргэсэн байх:</p> <p>2.1 загвар нисгэх этгээдийн нэр, хаяг, утасны дугаар;</p> <p>2.2 загварыг нисгэхээр санал болгож байгаа байршил;</p> <p>2.3 санал болгож байгаа үйл ажиллагааг явуулах өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;</p> <p>2.4 <u>агаарын хөлгийн загварын төрөл, тоо</u>;</p> <p>2.5 газрын гадаргуугаас дээш ямар өндөрт нисгэх тухай.</p>	
<p><b>101.209. Шууд харж удирдах үйл ажиллагаа</b></p> <p>(a) <u>Энэ зүйл нь дараах төрлийн агаарын хөлөгт хамаарна:</u></p> <p>(1) <u>алсын удирдлагатай агаарын хөлөг;</u></p> <p>(2) <u>чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар.</u></p> <p>(b) <u>Энэ зүйл хамаарах дараах тохиолдолд аливаа этгээд нь агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:</u></p> <p>(1) <u>агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэх, орчны агаарын зайн аливаа хэсэг нь тухайн этгээдийн хараанаас саадаар халхлагдсан; эсхүл</u></p> <p>(2) <u>тухайн агаарын хөлгийг шууд харах этгээдийн хараа цаг уурын нөхцөлөөр халхлагдсан.</u></p> <p>(c) <u>Энэ зүйл хамаарах агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь дараах шаардлагыг байнга мөрдөх үүрэгтэй:</u></p> <p>(1) <u>тухайн агаарын хөлгийг шууд харах нөхцөлийг байнга хадгалах;</u></p> <p>(2) <u>тухайн агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа орчны агаарын зайг харах боломжтой байх;</u></p>	<p><b>101.209. Цаг агаарын хязгаарлалт</b></p> <p>(a) Удирдлагатай агаарын хөлгийн загвараас бусад төрлийн загварыг дараах нөхцөлд нисгэхийг хориглоно:</p> <p>1/ алсын барааны харагдац 3 км-ээс бага аливаа талбайд, эсхүл</p> <p>2/ агаарын хөлгийн загварын нислэгийн бүх түвшинд үүлтэй байвал.</p>	<p>-Amend.7-оор нэмэгдсэн</p>



<p>(3) <u>түхайн агаарын хөлгөөр, үүлний сууриас доогуур үйл ажиллагаа гүйцэтгэх.</u></p> <p>(d) <u>Энэ зүйлийн зорилгоор, шууд харах гэж ажиглагч этгээд эгц шулуун шугамаар тод харахыг ойлгох бөгөөд, үүнд дараах төхөөрөмжийг ашиглаж болно:</u></p> <p>(1) <u>түхайн хэрэглэгчийн хэвийн бус харааг засахад ашигладаг боловч хэвийн хараанаас илүү сайн болгодоггүй, нүдний шил, контакт линз, эсхүл тэдгээртэй төстэй хэрэгсэл, гэхдээ электрон, механик, цахилгаан соронзон, оптик эсхүл электрон-оптик хэрэглэл хэрэглэхгүйгээр; эсхүл</u></p> <p>(2) <u>дүрсийг дэлгэцээр харж удирдах систем болон сургалтад хамрагдсан, мэдлэг чадвартай ажиглагч дараах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байгаа бол:</u></p> <p>(i) <u>түхайн агаарын хөлгийг шууд харж байх;</u></p> <p>(ii) <u>түхайн агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа орчны агаарын зайг харж хянах;</u></p> <p>(iii) <u>түхайн агаарын хөлгийг удирдаж байгаа этгээдтэй шууд холбоотой байх.</u></p>		
<p><b>101.211. Шөнийн үйл ажиллагаа</b>  Дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь алсын удирдлагатай агаарын хөлөг, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) дотор орчинд; эсхүл  (2) халхлагдсан үйл ажиллагаа.</p>	<p><b>101.211. Шөнийн нислэг</b></p> <p>(a) Удирдлагатай агаарын хөлгийн загвараас бусад төрлийн загварыг, битүү байгууламж дотор нисгэхээс бусад тохиолдолд, шөнийн цагт нисгэхийг хориглоно.</p> <p>(б) Аливаа этгээд, агаарын хөлгийн загварыг нисгэхдээ газарт хөдөлгөөн үйлдэж байгаа болон агаарт байгаа, нисгэгчтэй бүх төрлийн агаарын хөлгийн хөдөлгөөн болон нислэгийн замд саад учруулахыг хориглоно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>101.213. Хөдөлгөөний давуу эрх</b></p> <p>(a) <u>Алсын удирдлагатай агаарын хөлөг, эсхүл утсан удирдлагатай агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь, түхайн агаарын хөлгийг удирдаж байгаа этгээд газар дээр болон нислэгт байгаа нисгэгчтэй агаарын хөлгүүдээс зайтай байж, зам тавьж өгч байгааг бататгах үүрэгтэй.</u></p> <p>(b) <u>Чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь агаарын хөлгийг хөөргөхөөс өмнө, түхайн агаарын хөлгийн үйл ажиллагааны үед газар дээр болон нислэгт байгаа нисгэгчтэй агаарын хөлгөөс зайтай, саадгүй байхыг</u></p>	<p><b>101.213. Нөөц</b></p>	<p>-Amend.6-аар нэмэгдсэн</p>

<p><u>бататгах үүрэгтэй.</u></p> <p><b>101.215. Агаарын хөлгийн жингийн хязгаар</b></p> <p>(a) <u>Аливаа этгээд нь нийт жин нь 25 кг-аас дээш жинтэй, алсын удирдлагатай агаарын хөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.</u></p> <p>(b) Агаарын хөлөг болон түүнд хийсэн модификаци нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь нийт жин нь <u>15 - 25 кг хүртэл</u> жинтэй, алсын удирдлагатай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) <u>101.202-т заасан зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагын эрхийн хүрээнд үйлдвэрлэгдсэн, эсхүл үзлэг шалгалт хийгдэж зөвшөөрөгдсөн байх;</u></p> <p>(2) <u>101.202-т заасан зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагын эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэдэг байх.</u></p>	<p><b>101.215. Радио удирдлагатай агаарын хөлгийн загвар</b></p> <p>(a) <u>10-25 кг жинтэй</u>, радио удирдлагатай агаарын хөлгийн загварыг, ИНЕГ-ын эрх бүхий этгээд, эсхүл ИНЕГ-ын даргаас эрх шилжүүлж авсан этгээдийн зөвшөөрлөөр нисгэнэ.</p>	<p>-Amend.6-аар нэмэгдсэн</p>
<p><b><u>F Бүлэг - Жиро-глайдер болон Парасэйл</u></b></p> <p><b><u>101.251. Хамрах хүрээ</u></b></p> <p><u>Энэ Бүлэг нь жиро-глайдер болон парасэйлийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.</u></p>	<p><b>101.251. Нөөц</b></p>	<p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>
<p><b>101.253. Аэродром</b></p> <p>(a) Дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь жиро-глайдер, эсхүл парасэйлээр аэродром дээр, эсхүл аэродромын хил хязгаараас 4 км дотор үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) <u>жиро-глайдер</u>, эсхүл парасэйл нь хяналтгүй аэродромд, дараах үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол:</p> <p>(i) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй хийсэн гэрээний дагуу;</p> <p>(ii) AGL 120 м-ээс (400 ft) дээшгүй өндөрт; эсхүл</p> <p>(2) <u>жиро-глайдер</u>, эсхүл парасэйл нь хяналттай аэродромд, тухайн аэродромын НХҮ-ний нэгжээс авсан зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол.</p>	<p><b>101.253. Аэродром</b></p> <p>(a) Аливаа этгээдийг дор дурдсанаас бусад тохиолдолд, дараах аэродром дээр, эсхүл түүний хил хязгаараас 4км-ээс дотогш зайд <u>жиропланер</u>ээр нислэг үйлдэхийг хориглоно:</p> <p>1/ нислэгийн хөдөлгөөний удирдлагагүй аэродромд:</p> <p>1.1 аэродром эзэмшигчтэй урьдчилан тохиролцсоны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа бол;</p> <p>1.2 газрын гадаргуугаас дээш 120 м (400 фут) -ээс дээшгүй өндөрт нисгэж байгаа бол.</p> <p>2/ нислэгийн хөдөлгөөний удирдлагатай аэродромд уг үйл ажиллагааг НХҮ-ний байгууллагын зөвшөөрөлтэй гүйцэтгэж байгаа бол.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

<p>(b) Аливаа этгээд нь жиро-глайдер, эсхүл парасэйлээр дараах үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) аэродромын агаарын хөлгийн хөдөлгөөнт бүс дээр, эсхүл дээгүүр; эсхүл</p> <p>(2) аэродромын ашиглагдаж байгаа хөөрч буух зурвас, эсхүл хөөрч буух зурвасны үргэлжилсэн талбай дээр, эсхүл дээгүүр.</p>	<p>(б) <u>Жиропланер</u>ээр дараах тохиолдолд нислэг үйлдэхийг хориглоно:</p> <p>1/ агаарын хөлгийн идэвхтэй хөдөлгөөнтэй байгаа аэродромын талбай дээр, буюу дээгүүр нь, эсхүл</p> <p>2/ нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа ХБЗ дээр, буюу дээгүүр нь.</p>	
<p><b>101.255. Агаарын зай</b> AGL 120 м-ээс (400 ft) дээш өндөрт жиро-глайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах шаардлагыг хангах үүрэгтэй:</p> <p>(1) <u>жиро-глайдер</u>, эсхүл парасэйл нь аэродромын хил хязгаараас 4 км-ээс доошгүй хол зайд байгааг бататгах;</p> <p>(2) G ангиллын агаарын зайд <u>үйл ажиллагаа эрхлэх</u>;</p> <p>(3) тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24 цагаас доошгүй хугацааны өмнө дараах мэдээллийг NOTAM-д хүргүүлэх:</p> <p>(i) тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, хаяг, утасны дугаар;</p> <p>(ii) тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;</p> <p>(iii) тухайн <u>жиро-глайдер</u>, эсхүл парасэйлийн товч тайлбар (хэмжээ, давамгайлсан өнгийг багтаасан);</p> <p>(iv) тухайн жиро-глайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа гүйцэтгэх өндөр.</p>	<p><b>101.255. Агаарын зай</b></p> <p>(a) Газрын гадаргуугаас дээш 120 м (400 фут)-ээс дээш өндөрт <u>жиропланер</u>ээр нислэг үйлдэх этгээдэд дараах шаардлага тавигдана:</p> <p>1/ аэродромын хил хязгаараас 4 км-ээс багагүй зайд нисэх;</p> <p>2/ G ангиллын агаарын зайд нисэх;</p> <p>3/ нислэг эхлэхээс 24 цагийн өмнө дараах мэдээллийг NOTAM-д хүргэх:</p> <p>3.1 нислэг үйлдэх этгээдийн нэр, хаяг, утасны дугаар;</p> <p>3.2 санал болгож байгаа үйл ажиллагааг явуулах өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;</p> <p>3.3 <u>жиропланер</u>ын товч танилцуулга (хэмжээ болон давамгайлах өнгийг заасан байх);</p> <p>3.4 нислэг үйлдэх өндөр.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>101.257. Цаг уурын хязгаарлалт</b></p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, <u>жиро-глайдер</u>, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах шаардлагыг мөрдөх үүрэгтэй:</p> <p>(1) үүлний доогуур, 120 м-ээс (400 ft) ойр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх;</p> <p>(2) үйл ажиллагааг, газрын алсын барааны харагдац 5 км-ээс багагүй байх орчноор хязгаарлах.</p> <p><u>(b) Энэ зүйлийн (a) нь жиро-глайдер, эсхүл парасэйлийн халхлагдсан үйл ажиллагаанд хамаарахгүй.</u></p>	<p><b>101.257. Цаг агаарын хязгаарлалт</b></p> <p>(a) Аливаа этгээдийг, дараах нөхцөлд <u>жиропланер</u>ээр нислэг үйлдэхийг хориглоно:</p> <p>1/ үүлний сууриас доош 120 м (400 фут)-ийн ойр зайд;</p> <p>2/ алсын барааны харагдац 5 км-ээс бага аливаа талбайд.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p> <p>-орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p><b>101.259. Шөнийн үйл ажиллагаа</b> Аливаа этгээд нь <u>жиро-глайдер</u>, эсхүл <u>парасэйлээр</u> шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.</p>	<p><b>101.259. Шөнийн нислэг</b></p> <p>(a) Аливаа этгээд шөнийн цагаар <u>жиропланер</u>ээр нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.</p>	<p>-Парасэйлийн үйл ажиллагаа зохицуулагдсан</p>
<p><b>101.261. Нислэгт тэнцэх чадвар</b></p>	<p><b>101.261. Нислэгт тэнцэх чадвар</b></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p><u>Жиро-глайдер</u>, эсхүл <u>парасэйлээр</u> үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь <u>төхөөрөмжийг тухайн зориулалтад тохирч байгаа болон үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу</u> нислэгт тэнцэх нөхцөлийг хангаж байгааг бататгах үүрэгтэй.</p>	<p>(a) <u>Жиропланер</u>ээр нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх аливаа этгээд тухайн <u>жиропланер</u> нислэг үйлдэх чадвартай гэдгийг бататгана.</p>	
<p><b>101.263. Аюулгүй байдлын төхөөрөмж</b>  <u>Жиро-глайдер</u>, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь жиро-глайдер, парасэйлээр тээвэрлэгдэж байгаа хүн бүр дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) усан дээгүүр нислэг үйлдэх үед, эсхүл халин нисэх зай нь усан дээр байхаар бол, тохирсон хөвөх туслах хэрэгсэл өмссөн байх;</p> <p>(2) хамгаалалтын хатуу малгай өмссөн байх;</p> <p>(3) тухайн <u>жиро-глайдер</u>, эсхүл парасэйлд даруулга бүсээр бэхлэгдсэн байх;</p> <p>(4) <u>парасэйлийн шүхрийн холбогч гогцооноос утас ороогч дамар хүртэл хэмжсэн, 180 м-ээс (600 ft) их уртасгасан чирэх татлагаар чирэгдэж хөөрөх парасэйлийн үйл ажиллагааны хувьд, хэрэв онцгой нөхцөл үүсвэл, холбоо барих боломжтой хэлбэрээр тоноглогсон байх.</u></p>	<p><b>101.263. Аюулгүй ажиллагааг хангах</b>  (a) <u>Жиропланер</u>ээр нислэг үйлдэж байгаа аливаа этгээд нь:</p> <p>1/ усан гадаргуу дээгүүр нислэг үйлдэхдээ хамгаалалтын хөвөгч хантаазтай байна;</p> <p>2/ газрын гадаргуу дээгүүр нислэг үйлдэхдээ хамгаалалтын малгайтай байна;</p> <p>3/ <u>жиропланерт</u> бэхлэгдсэн даруулга бүсийг тогтмол хэрэглэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p> <p>-Amend.4-өөр нэмэгдсэн.</p>
<p><b>101.265. Нислэгийн өмнөх зааварчилгаа</b>  <u>Жиро-глайдер</u>, эсхүл <u>парасэйлээр</u> үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь, зорчигч бүр дараах мэдээллийг агуулсан нислэгийн өмнөх зааварчилгааг нислэг бүрийн өмнө авдаг болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн нислэгийн шинж чанар;</p> <p>(2) тухайн нислэгийн хэвийн үйл ажиллагааны журам;</p> <p>(3) дараах шаардлагыг багтаасан онцгой нөхцөлийн журам:</p> <p>(i) <u>ослын төхөөрөмжийн байрлал болон түүнийг хэрэглэх;</u></p> <p>(ii) <u>усанд буулт үйлдсэн, эсхүл чирэх татлага тасарсан үед мөрдөх журам;</u></p> <p>(iii) <u>онцгой нөхцөл үүссэн үед жиро-глайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоо барих арга.</u></p>	<p><b>101.265. Нислэгийн өмнөх зааварчилгаа</b>  (a) <u>Жиропланер</u>ээр нислэг үйлдэх этгээд нь нислэг бүрийн өмнө дараах зааварчилгааг эрх бүхий этгээдээс авна:</p> <p>1/ нислэгийн утга, мөн чанар, нислэгийн үед хийгдэх маневр;</p> <p>2/ нислэгийн үйл ажиллагаанд мөрдөх стандарт журам;</p> <p>3/ онцгой нөхцөл байдлын үед ажиллах журам.</p>	<p>-Илүү тодорхой болсон.</p> <p>-Amend.4-өөр нэмэгдсэн</p>
<p><b>101.267. Онцгой нөхцөлийн үед чирэх татлагыг салгах</b>  Онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд аливаа этгээд нь</p>	<p><b>101.267. Ослын холбоосыг салгах</b>  (a) Аливаа этгээд нь онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд,</p>	<p>-“Towline-холбоос” гэснийг “чирэх холбоос” гэж</p>

<p>нислэгт <a href="#">жиро-глайдер</a>, эсхүл <a href="#">парасэйлийн чирэх</a> татлагыг салгахгүй байх үүрэгтэй.</p>	<p>нислэгийн үед <a href="#">жиропланерийн холбоосыг</a> салгахыг хориглоно.</p>	<p>өөрчлөгдсөн</p>
<p><b>101.269. Үйл ажиллагааны журам</b>  <a href="#">Жиро-глайдер</a>, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь үйлдвэрлэгчийн зөвлөсөн үйл ажиллагааны журам болон хязгаарлалтыг мөрдөх үүрэгтэй.</p>	<p><b>101.269. Үйл ажиллагааны журам</b>  (а) <a href="#">Жиропланер</a>ээр нислэг үйлдэх этгээд нь тухайн <a href="#">жиропланерыг</a> үйлдвэрлэгчээс гаргасан бүх зөвлөмжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>101.271. Салхины хурд</b>  <a href="#">Парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:</a>  (1)<a href="#">парасэйлээр үйл ажиллагаа гүйцэтгэж байхдаа, тухайн байрлалын салхины хурдыг нарийн тогтоох болон хянах төхөөрөмж, эсхүл аргыг ашиглах;</a>  (2)<a href="#">салхины тогтвортой хурд нь 10 м/с-ээс (20 knot) их нөхцөлд парасэйлээр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх.</a></p>		<p>-Amend.4-өөр нэмэгдсэн</p>
<p><b>101.273. Зорчигчийн насны хязгаарлалт</b>  <a href="#">Парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх үүрэгтэй:</a>  (1)<a href="#">8-11 настай зорчигчийг (solo passenger) тээвэрлэх үед, парасэйл шүхрийн холбогч гогцооноос утас ороогч дамар хүртэл хэмжсэн, 90 м-ээс (300 ft) их уртасгасан чирэх татлагаар парасэйлийн үйл ажиллагаа;</a>  (2)<a href="#">хэрэв онцгой нөхцөл үүсвэл, бага насны зорчигчид туслалцаа үзүүлэх чадвартай 18-аас доошгүй настай өөр зорчигч дагалдахаас бусад тохиолдолд, 8-аас доош насны зорчигчийг парасэйлээр тээвэрлэх үйл ажиллагаа.</a></p>		<p>-Amend.4-өөр нэмэгдсэн</p>

Дүрмийн боловсруулалтын хэлтэс